Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7-р хавсралт

# БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 1. Баян- өлгий аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2.2.4, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3 дахь заалтыг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 1.1 | Хүн амын эрүүл мэндийг сайжруулах, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглүүлэн эрүүл мэндийн байгууллагуудыг стандартын шаардлага хангасан орон байраар хангах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 50% | Шинэ байртай болно | Ногооннуур сумын Улаанхад багийн 5 ортой эмнэлэг ашиглалтанд орсон. | 100% |
| 1.2 | Гадаадын зээл, тусламж, хөтөлбөр, олон улсын хандивлагч байгууллагуудад хандаж, хөрөнгө оруулалт хийлгэх | 1250.0 сая | Тоогоор | 30% | Шинэ байртай болж тоног төхөөрөмж өөр хангагдна | Канад улсын тусламжтайгаар 70 сая төгрөгөөр Ногооннуур сумын ЭМТ-ийн эхийн амрах байрыг бүрэн тохижуулсан. | 100% |
| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2. Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2.2.4, Баян-Өлгий аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2.2.4, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3 дахь заалт | | | | | | | |
| 2.1 | Эрүүл мэндийн салбарын автопарк шинэчлэлтийг төлөвлөлтийн дагуу үе шаттай шийдвэрлүүлэх | 180 сая | Машины тоогоор | 85% | Автопарк шинэчлэлт хийгдэнэ | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар НЭ, Булган, Цэнгэл сумын ЭМТөвүүд түргэн тусламжийн шинэ авто машинаар хангагдсан. 12 сум, 1 тосгоны нийт 70 бага эмчийг мотоциклээр унаажуулсан. | 100% |
| 2.2 | Эрүүл мэндийн байгууллагуудыг стандарт технологийн төлөвлөлтийн | 1250.0 сая | Тоогоор | 80% | 85,0 % | Аймгийн нэгдсэн эмнэлэг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 178,8 сая төгрөгийн өртөгтэй суурин рентген, Люксембург улсын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дагуу нэн шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангаж, тоног төхөөрөмжийн асуудлыг шат дараалан шийдвэрлэх | | | | | төслөөр 120,0 сая төгрөгийн өртөгтэй зүрхний ЭХО, Төсөл Дэззэрт ОУ Энэрлийн Байгууллагын тусламжаар 3,1сая төгрөгийн өртөгтэй нярайн шарлагын аппарат 5ш, 3,4 сая төгрөгийн өртөгтэй нярайн шарлалт хэмжигч аппарат 5ш, Глобал сангийн тусламжаар 5,0 сая төгрөгийн өртөгтэй Зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар хангагдсан.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Алтанцөгц, Буянт сумын ЭМТөвүүд 20,9 сая төгрөгийн өртөгтэй бүрэн автомат биохими, 5,0 сая төгрөгийн өртөгтэй Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, 3,4 сая төгрөгийн өртөгтэй шээсний анализатор, 27,2 сая төгрөгийн өртөгтэй хэвлийн ЭХО аппаратаар тус тус хангагдсан бол Дэлүүн сумын ЭМТ 27,2 сая төгрөгийн өртөгтэй хэвлийн ЭХО, Баяннуур сумын ЭМТ 20,9 сая төгрөгийн өртөгтэй бүрэн автомат биохимийн анализатор, 3,4 сая төгрөгийн өртөгтэй шээсний анализатор, Бугат сумын ЭМТөв орон нутгийн хөрөнгө оруулалтаар 20 сая төгрөгийн өртөгтэй шүдний тоног төхөөрөмжүүдээр тус тус хангагдсан. | |
| 2.3 | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн баталгаат засвар, үйлчилгээг боловсронгуй болгох, инженерүүдийг чадавхжуулах | 45.0 сая | Тоног төхөөрөмж-ийн тоогоор | 70% | 80% | Төсөв батлагдаагүй. | |
| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 3. Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.12, Баян- Өлгий аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2.2.4, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3 дахь заалт | | | | | | | |
| 3.1 | 100 ортой Нэгдсэн эмнэлгийн байрыг ашиглалтанд оруулах | 28656.2 сая | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | 70% | Барилгын ажил 100% хувьтай гүйцэтгэгд-сэн байна. | Нэгдсэн эмнэлгийн шинэ барилга 2024 оны 12-р сарын байдлаар 90%-ийн гүйцэтгэлтэй байна. 2025 онд ашиглалтанд орно. | 90% |
| 3.2 | Ногооннуур сумын Улаанхад багийн эмнэлгийн барилгыг ашиглалтад оруулах | 770.4 сая | Барилгын ажлын гүйцэтгэли | Барилгын ажлын гүйцэтгэл | Барилгын ажил 100% хувьтай | Ногооннуур сумын Улаанхад багийн 5 ортой эмнэлэг баригдаж ашиглалтанд орсон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | йн хувь | 70 хувьтай. | гүйцэтгэгд-сэн байна | | |
| 3.3 | Өлгий сумын Хотгор багийн эмнэлгийн барилгыг ашиглалтад оруулах | 1003.3 сая | Барилгын ажлын гүйцэтгэли йн хувь | Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувьтай. | Барилгын ажил 100% хувьтай гүйцэтгэгд-сэн байна | Санхүүжилт дутуу олгогдсон. 2025 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. | 70% |
| 3.4 | Дэлүүн сумын эрүүл мэндийн төвийн хуучин барилгын засвар хийх | 170.0 сая | Ажлын гүйцэтгэли йн хувь | Барилгын ажлын гүйцэтгэл 50 хувьтай. | Барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь, ашиглалтад хүлээлгэн өгөх | Дэлүүн сумын ЭМТөвийн хуучин барилгын их засварын ажил дуусах шатанд явж байна. Он гарахаас өмнө ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. | 100% |
| 3.5 | Толбо сумын эрүүл мэндийн төвийн барилгыг стандартад нийцүүлэн засварлах | 60,0 сая | Засварын ажлын гүйцэтгэли йн хувь | Засварын ажлын гүйцэтгэл 0 хувьтай. | Засварын ажлын гүйцэтгэл | Толбо сумын ЭМТ-д засварын ажил хийгдэж дууссан. Барилгын бүх өрөөнүүдийн хаалгыг сольж, гадна дотор талыг будаж, паркет шаал хийгдсэн. | 100% |
| 3.6 | Сагсай сумын эрүүл мэндийн төвийн засвар хийх | 100,0 сая | Засварын ажлын гүйцэтгэли йн хувь | 0 | 100% | Сагсай сумын ЭМТ-ийн барилгын их засварын ажил хийгдэж дууссан. Барилгын гадна дотор талыг шавардаж, эмульс, шохойгоор будаж паркет шал хийгдсэн. Ариун цэврийн өрөөнүүдийн шал болон хананд плита наасан. | 100% |
| 3.7 | Цэнгэл сумын эрүүл мэндийн төвийн барилгын засвар хийх | 130,0 сая | Засварын ажлын гүйцэтгэли йн хувь | 70% | 100% | Цэнгэл ЭМТ-ийн дээврийн засварын ажил дуусах шатанд явж байна. | 90% |
| 3.8 | Нэгдсэн эмнэлгийн сэргээн засах тасгийн засвар хийх | 60,0 сая | Барилгын ажлын гүйцэтгэли йн хувь | 0 | 100% | Нэгдсэн эмнэлгийн сэргээн засах тасгийн засварын ажил хийгдэж дууссан. Бүх өрөөнүүдийг эмнэлгийн зориулалттай тосон будгаар будаж, усан эдэлгээтэй өрөөнүүдийн хаалгыг сольж, шал болон хананд плита нааж, коридор болон эмч нарийн өрөөнд паркет шал хийгдсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.9 | Бугат сумын эрүүл мэндийн төвийн барилгын засвар хийх | 20,0 сая | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | 0 | 100% | Бугат сумын хуучин эрүүл мэндийн төвийн барилгын гадна дотор талыг эмульс болон шохойгоор будаж, цонх хаалгыг сольсон. | 100% |
| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 4. Монгол улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2.2.4, Баян-Өлгий аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2.2.8, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.5 дахь заалт | | | | | | | |
| 4.1 | Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга, хэлбэрийг нэвтрүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тоо, чанартай уялдуулан тооцоолол хийж,эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | 32300, 0 сая | ЭМД-аас авсан санхүүжилт-ийн хувь, хэмжээ | 90%-иас доошгүй байсан. | 95%-иас доошгүй байх | Эхний 11 сарын байдлаар ЭМД-аас авах гүйцэтгэлийн санхүүжилтийн төлөвлөгөөний хэмжээ 33,318,496,226.21 төгрөг, гүйцэтгэл 95.5% байна. | 100% |
| 4.2 | Эрүүл мэндийн улсын төсвийн байгууллагын УИХурлаас батлагдсан төсөв, гүйцэтгэлээр санхүүжих байгууллагуудын 2024 оны төсвийн хуваарийг хийж, харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэн батлуулах | 37400, 0 сая | Төсвийн хуваарийг хийж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэн батлуулсан эсэх | Төсвийн хуваарийг хийж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэн батлуулах | Төсвийн хуваарийг хийж, төсвийнерөнхийлөн захирагчид хүргүүлж батлуулсан байх | Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн 2024 оны нэг иргэний санхүүжилтийн мөнгөн дүн болон үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний мөнгөн дүнг төсвийн хууль тогтоомжийн дагуу хуваарилж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэн батлуулж, батлуулсан төсвийн хуваарийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн ажилласан. Мөн энэ оны 4 дүгээр сараас нэмэгдэх цалингийн нэмэгдэлтэй холбоотой нэг иргэний санхүүжилтэд өөрчлөлт орсон, хуваарийг хийж явуулсан. | 100% |
| 4.3 | Эрүүл мэндийн байгууллагуудын 2023 оны бүтэн жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан, 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг нэгтгэх | - | 2023 оны бүтэн жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан, | 2023 оны бүтэн жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан, 2024 оны хагас | 2023 оны бүтэн жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан, 2024 оны хагас жилийн санхүүгийн | Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалт, 54 дүгээр зүйлийн 54.2, 54.4, 54.5 дахь заалтуудын дагуу холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлэн байгууллагуудын 2023 оны бүтэн жилийн аудитлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайланг 2024 оны 3 дугаар сарын 25-ны дотор, 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг 7 дугаар сарын 25-ны дотор бэлтгэн гаргаж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг холбогдох тооцоо нийлсэн акт, судалгааны хамт авч хянан, төсвийн ерөнхийлөн захирагчид хугацаанд хүргүүлсэн эсэх | жилийн санхүүгийн тайланг холбогдох тооцоо нийлсэн акт, судалгааны хамт авч хянан, төсвийн ерөнхийлөн захирагчид хугацаанд хүргүүлэн ажилласан. | тайланг холбогдох тооцоо нийлсэн акт, судалгааны хамт авч хянан, төсвийн ерөнхийлөн захирагчид хугацаанд хүргүүлсэн байх | төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн. | |
| 4.4 | Эрүүл мэндийн улсын төсвийн байгууллага болон гүйцэтгэлээр санхүүжих байгууллагуудын 2024 оны төсвийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, ЭМЯ-нд хүлээлгэж өгөх | - | ЭМБ-уудын 2023 оны төсвийн төлөвлөгөө-ний төслийг нэгтгэн боловсруулж, хугацаанд хүргүүлсэн эсэх | ЭМБ-уудын 2023 оны төсвийн төлөвлөгөөний төслийг нэгтгэн боловсруулсан байна | ЭМБ-уудын 2023 оны төсвийн төлөвлөгөө-ний төслийг нэгтгэн болов сруулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хугацаанд хүргүүлсэн байна | Эрүүл мэндийн улсын төсвийн байгууллага болох ЭМГ, ЗӨСТөвийн 2025 оны төсвийн төлөвлөгөөний төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг боловсруулж, 518 дугаартай албан тоотоор төсвийн ерөнхийлөн захирагчид хугацаанд хүргүүлсэн. | 100% |
| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 5. Аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2.2.9, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.7 заалтыг хэрэгжүүлэх | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1 | Эрүүл мэндийн салбарын хэмжээнд хүний нөөцийн бодлогыг оновчтой зохион байгуулах, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжиж ажиллах | 30 сая | Чадавх жуулах сургалтад хамрагдсан хувь | 85% | 90% | Эрүүл мэндийн яам, Улсын төв эмнэлгүүд болон сургалт эрхлэгч байгууллагуудаас зохион байгуулагдсан цахим сургалт, зөвлөгөөн уулзалтад тухай бүр холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан. Мөн дээрх байгууллагуудаас зохион байгуулагдсан цахим сургалт, зөвлөгөөн уулзалтад тухай бүр холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан. 2024 онд аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн төлөвлөлтийн дагуу салбар нэгжүүдээс 2024-2025 онд улсын төсвийн санхүүжилтээр, байгууллагын зардлаар суралцуулах эмч, эмнэлгийн мэргэжилтний захиалгыг хийж, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/125 дугаар тушаалаар батлагдсан хязгаарын дагуу эмч мэргэжилтнүүдийг улсын төсвийн санхүүжилтээр суралцуулж байна. Тайлангийн жилд 14 их эмчийг үндсэн мэргэшлээр, төрөлжсөн мэргэшлийн 6 сарын сургалтад 8 их эмч, мэргэжил дээшлүүлэх сургалтад 5 эмчийг хамруулсан бол сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний 3 сарын төрөлжсөн мэргэшлийн сургалтад 34 мэргэжилтэнг, сувилагчийн мэргэжил дээшлүүлэх дээшлүүлэх сургалтад 6 сувилагчийг тус тус хамруулан ажилласан. | 100% |
| 5.2 | Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод туршлага судлуулан мэргэшүүлэх, урт богино хугацааны сургалтад хамруулж, чадавхжуулна. | 10 сая | Сургалтанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хувь | 85% | 90% | Аймгийн Нэгдсэн эмнэлэг, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын 4 эмч, 3 сувилагч, 5 багийн бага эмч БНХАУ-ын Хөх хотод богино хугацааны сургалтад тус тус хамрагдсан. | 100% |
| 5.3 | Аймгийн Нэгдсэн эмнэлэг болон сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд | 30 сая | Төгсөлтийн дараах сургалтан | 93% | 95% | 2024 онд Булган сумын эрүүл мэндийн төвийг эх барих эмэгтэйчүүдийн эмчээр, Бугат сумын эрүүл мэндийн төв дотрын эмчээр, Жансая өрхийн эрүүл мэндийн төв | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шаардлагатай үндсэн нарийн мэргэжлийн эмч нарыг бэлтгэх, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх, суманд ажиллахаар очсон эмч, мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, багийн эмч нарын ажиллах орчин нөхцлийг сайжруулж, шаардлагатай эмнэлгийн хэрэгслээр хангах | | д хамрагдсан эмч мэргэжилт-ний хувь | | | хүүхэд судлалын үндсэн мэргэшлийн эмчээр, аймгийн Нэгдсэн эмнэлэг хүүхэд судлалын 2, сэргээн засах судлалын 2 үндсэн мэргэшлийн эмчээр тус тус хангагдсан болно.<br>Сум өрхийн эрүүл мэндийн төвийн захиалгаар 2023 онд 7 эмч, 2024 оноос 5 эмч үндсэн мэргэшлийн сургалтад улсын төсвийн санхүүжилтээр тус тус суралцаж байна. Зарим сумдын захиалгаарулсын төсвийн санхүүжилтээр суралцсан эмч нар нь ар гэрийн асуудал, захиалагч эрүүл мэндийн байгууллагуудад мэргэшлийн орон тоо байхгүй, хүүхэд асрах чөлөөтэй гэх шалтгаанаар гэрээт газарт очиж ажиллаагүй. Ногооннуур сумын ЭМТөвийн сэргээн засахын эмч 1 , Цэнгэл сумын ЭМТөвийн мэдээгүйжүүлэг судлалын эмч 1, Раушан өрхийн ЭМТөвийн өрхийн анагаах судлалын эмч 1, Булган сумын хүүхэд судалын 1 эмч байна. Дээрхи эмч нарыг гэрээний дагуу гэрээт газарт тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэл өгч ажиллаж байна . | |
| 5.4 | Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэшлийн зэргийн шалгалтанд хамруулах ажлыг зохион байгуулах | - | Мэргэжлийн зэрэг шинээр хамгаалсан эмч, мэргэжилт-ний тоо | 9 | 15 | Мэргэшлийн зэрэгтэй холбоотой гарсан тушаал шийдвэр, холбогдох мэдээллийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэдээллээр хангаи ажилласан. Мэргэшлийн зэрэг горилох эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн материалын бүрдүүлэлтэд хяналт тавьж Мэргэшлийн зэрэг горилох шалгалтад орох мэргэжилтнүүдэд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Тайлангийн жилд 4 эмч, 8 сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтэн мэргэжлийн зэрэг хамгаалсан болно. | 100% |
| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 6. Баян-Өлгий аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2.2.5, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.9 заалт болох эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангуулж хүртээмжийг нэгдүүлнэ | | | | | | | |
| | Эм эмнэлгийн хэрэгслийн | Эрүүл | Эм эмнэлгийн | 90% | 100% | Сангийн сайдын 2017 оны 234 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий гэрээ | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1 | хэрэгцээг оновчтой тооцон худалдан авах ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, ерөнхий гэрээгээр нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулна. | мэндийн даатгалын сан | хэрэгслийн хангалтийн хувь | | | байгуулах журмын дагуу 141 нэрийн эм, эмнэлгийн хэрэгслийн захиалгыг нэгтгэж цахим дэлгүүрээс худалдан авалт хийж харьяа байгууллагуудад түгээсэн. 2024 оны жилийн байдлаар 1,1 тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан байна. Уг үйл ажиллагааг хэрэгжүүлснээр эмийн төсвийг хэмнэх, чанартай эмээр харьяа байгууллагуудыг хангах, зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг сайжруулах боломжтой. | 100% |
| 6.2 | Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг “Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн хүрээнд зохион байгуулна. | Эрүүл мэндийн даатгалын сан | Харьяа байгууллагууд боломжийн үнэтэй чанартай, баталгаатай эмээр хангагдсан байна. | 80% | 90% | Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум тосгоны эрүүл мэндийн төвийн 2024 оны эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу зохион байгуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем tender.gov.mn сайтад урилга нийтэлж, тус тендерт оролцох эм ханган нийлүүлэх байгууллагуудад тендерийн материалын талаар тодруулга мэдээллийг ЭМГ-ын даргын 161, 162, 166, 177, 190 тоот бичгээр хүргүүлсэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад багц тус бүрээр Сангийн сайдын 2023 оны А/258 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу үнэлэн шалгаруулж, хууль тогтоомжийн хүрээнд ил тод байдлыг ханган ажилласан.<br>Тендер шалгаруулалтын урилга, үр дүн, тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэж, тендерт шалгарсан болон шалгараагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар оролцсон компаниудад албан бичгээр мэдэгдэж, эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 2024/04-01 дугаартай гэрээ байгуулав. Тус тендерт 21 компани оролцож 15 компани шалгарав. | 100% |
| | Эрүүл мэндийн байгууллагуудын эм зүйн | - | Зөвлөмж хүргүүлж, | 70% | 80% | Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/10 дугаар тушаалын дагуу тусгай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.3 | тусламж үйлчилгээг сайжруулж “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль” болон бусад хууль журмууд, MNS 52:60 2015 стандартын хэрэгжилт, эмийг жороор олголтын байдалд батлагдсан удирдамжийн дагуу хяналт үнэлгээ хийж, зөрчлийг арилгаж, арга хэмжээ авч зөвлөмж хүргүүлэн ажиллах. | | тайлан бичсэн, үр дүнг тооцсон байна | | | зөвшөөрөл сунгуулах 8, шинээр авах 7, хаягийн өөрчлөлт хийх 1, тусгай зөвшөөрлийн эрх сэргээх 4, төлөвлөгөөт хяналт үнэлгээгээр 23 нийт 42 нийтийн үйлчилгээтэй хувийн хэвшлийн эмийн сан, 4 өрхийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн эм зүйн тусламж үйлчилгээнд хяналт үнэлгээ хийж 12-оос 37 заалт бүхий зөвлөмжийг ЭМГ-ын даргын 468 тоот бичгээр хүргүүлэв. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, аймгийн Тагнуулын газар, Цагдаагийн газрын холбогдох албан хаагчидтай хамтран эрүүл мэндийн байгууллагуудын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, зарцуулалт, эм хангамжийн байгууллагуудын худалдаж буй эмийн чанар аюулгүй байдалд хяналт үнэлгээ хийж илэрсэн зарим алдаа зөрчлийг газар дээр нь арилгуулж, гарсан үр дүнг удирдлагуудад танилцуулан цаашид авах арга хэмжээг зохион байгуулан ажилласан. | 100% |
| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 7. Хууль тогтоомж, төр засгийн удирдах дээд байгууллагын бусад чиглэлээр үүрэг болгосон ажил үйлчилгээ болон иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэх ба бусад ажил үйлчилгээ | | | | | | | |
| 7.1 | Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах /Архив албан хэрэг хөтлөлтийн хухай хуулийн 24, 25, 27 дугаар зүйл, Архив,албан хэрэг хөтлөлтийг зохих заавар, журмын дагуу хэрэгжүүлэх /Салбарын хэмжээнд/ | - | Хэрэгжилтийн хувь | 90% | 100% | Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 254 тоот бичгээр аймгийн ЗДТГ-ын архивын тасагт архивын тоо бүртгэлийн мэдээллийг хүргүүлсэн болно. Мөн аймгийн архивын тасгаас А4, А5 бланк, ЭМГ-ын даргын тушаалын бланкуудыг стандартыг авч өдөр тутмын ажилдаа ажил хэрэг болгон мөрдөн ажиллаж байна.<br>Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, 15.6.1 дэх заалтыг үндэслэн үйл ажиллагаа явуулж байна. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад архив, бичиг хэргийн шинэ хууль, журмын дагуу 60 хүнд сургалт зохион байгуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| 7.2 | Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ болон ЗГ-ын тогтоол, шийдвэр, ЗДТГ-аас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд биелүүлж ажиллах | | Тушаал, тогтоолын тоогоор | Үүрэг, даалгавры н хэрэгжилт сайжирна | Үүрэг даалгаврын гүйцэтгэл ийн хувь | Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ болон ЗГ-ын тогтоол, шийдвэр,ЗДТГ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг өмнө нь ирүүлсэн хууль тогтоомжийн жагсаалтын дагуу хагас бүтэн жилээр авдаг байсан бол 2024 оноос эхлэн сар бүр авч байна. Түүний дагуу тайлант онд эрүүл мэндийн салбартай холбоотой ирүүлсэн 3 заалтын тайланг нийт 12 удаа аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн. | 100% |
| 7.3 | Хөдөлмөрийн аюулгүй байдалын тухай хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэн ажиллах | Орон нутгий н төсөв | Хэрэгжүүл элтийн хувь | 80% | 90% | Харьяа эрүүл мэндийн байгууллагуудаас ХАБЭА-ийн жилийн төлөвлөгөөг гаргуулж, биелэлтэд хяналт тавьсан. Бүх харьяа эрүүл мэндийн байгууллагуудын ХАБ-ын төлөвлөгөөг авч нэгтгэсэн байгаа. Төлөвлөгөөний биелэлт 100% хүргэхээр төлөвлөгөө гаргаж ажиллаж байна. Эмнэлгийн ажилчдын хувьцас хэрэглэлийг 2 жил тутамд 2 ээлжээр, эмчийн цагаан халаад 2 жил тутуамд 2 ээлжээр, хослол болон хүрмийг 2 жил тутамд 1 ээлжээр журмын дагуу бэлтгэн нийлүүнэ.<br>Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас жил бүрийн зохион байгуулагддаг өдөрлөгт “Ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдөр” болгон олон улсын хэмжээнд тэмдэглэлт “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндэд уур амьсгалын өөрчлөлтийг үзүүлэх нөлөө” уриаг гаргасаны дагуу уриан дор харьяа эрүүл мэндийн байгуулагуудад ажил зохион байгуулах чиглэл өгч тайлан авч ЗДТГазарт хүргүүлсэн. | 100% |
| 7.4 | Харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг | Орон нутгий н төсөв | Мэргэжил арга зүйгээр хангагдсан байна | 80% | 90% | “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хууль шинэчлэн батлагдсантай холбоотой газрын даргын тушаалаар байгууллагын Ёс зүйн багийн бүрэлдэхүүнийг шинээр байгуулж багийн хурлыг 9 удаа хийж багийн ажиллах төлөвлөгөө, баримтлах дэг гэх мэт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хууль, эрх зүй, ёс зүй харилцаа хандлагыг сайжруулах чиглэлээр нэгдсэн бодлого чиглэлээр хангаж ажиллах | | | | | холбогдох эрх зүйн актаа газрын даргаар батлуулж, 4 өрхийн эрүүл мэндийн төвийн ёс зүйн багийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөмж өгсөн.<br>Гомдлын дагуу Бугат, Алтай, Баяннуур сумын эрүүл мэндийн төвүүдэд очиж ажиллаж “Ёс зүй ба харилцаа хандлага” сэдвээр сургалт явуулж арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн ЭМГ-ийн хамт олон, хувийн хэвшлийн эмнэлгүүд, харьяа эрүүл мэндийн байгууллагуудын дарга, эм найруулагч нарт “Эерэг сэтгэлгээ ба хандлага”, “Ёс зүйн зөрчил юунаас үүсдэг вэ?” сэдвээр давхцсан тоогоор 150 орчим эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт явуулсан.<br>Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсэгт “харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих”, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх хэсэгт “төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, зөрчлийг арилгах арга хэмжээг авах”; 9.1.3 дахь хэсэгт “урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар явуулах” чиг үүргийн хүрээнд нэгдсэн эмнэлэг, ЗӨСТ, сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төвүүдийн ёс зүйн дэд хорооны гишүүдэд нэг өдрийн сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтад нийт 53 хамрагдсан.<br>Албан хаагчдыг Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтад 2 удаа хамруулан ажилласан. Байгууллагын ww.health.bo.gov.mn цахим хуудасны ил тод байдал цэсэд Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагчийн ёс зүйн дүрэм", "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм"-ийг тус тус байршуулсан. 2024 онд ЭМГазрын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний мэргэжилтний ёс зүйн салбар хорооны бүрэлдэхүүн нь ЭМСайдын 2017 оны А/256 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан дүрэм, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 тушаал "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм"-ийг хэргэжилтийг тус тус ханган ажилласан бөгөөд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан болно. | |
| 7.5 | Салбарын хэмжээнд авлига ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Орон нутгийн төсөв | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна | 90% | 100% | Харьяа эрүүл мэндийн байгууллагуудыг "Авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх" сэдвээр цахим сургалт зохион байгуулж, арга зүйгээр хангасан. | 100% |
| 7.6 | Эрүүл мэндийн байгууллагуудын хүрээнд гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх талаар арга хэмжээ зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна | 90% | 100% | Гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх үүднээс харьяа эрүүл мэндийн байгууллагуудад Үндсэн хууль, авлига, ёс зүйн зөрчил зэрэг сэдвүүдээр нийт 5 удаа 120 хүнд сургалт зохион байгуулсан. | 100% |
| 7.7 | Байгууллагад ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт | - | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо | Барагдуул-сан өргөдөл, гомдлын тоо | Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг барагдуулах | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланг байгууллагын www.health.bo.gov.mn цахим хаягийн мэдээллийн ил тод цэсэд улирал тутам байршуулан ажиллаж байна. Тайлангийн жилд нийт 198 хүсэлт, өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнээс иргэнээс 172, ажилтнаас 28 өргөдлийг хянан хариу өгч ажилласан байна. Үүнээс шийдвэрлэсэн-186, судалж байгаа-12, шилжүүлсэн-15, өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх явцад хугацаа хэтэрч хариу өгсөн-3 байна. Өргөдлийн агуулгаас харахад иргэнээс ирсэн өргөдөл хүсэлтийг ажилд орох тухай, ажилтны хүсэлт нь чөлөө хүссэн, ажлаас | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чөлөөлөх, чөлөөний хугацаа дуусаад ажилдаа орох, тусламж, тэтгэмж хүссэн, тэтгэвэрт гарах хүсэлтүүд ээлж байна. Өргөдлийг хянах, судлах ажиллагаанд хуулийн хүрээнд баримт, үндэслэл, холбогдох чиг үүргийн нэгжээс санал авах, хүсэлт гаргасан иргэнээс нягтлан тайлбар авах, удирдлагуудад танилцуулах, шаардлагатай мэдээлэл цуглуулах, харъяалах нэгжээс санал авч хамтран судалж, шийдвэрлэж ажилласан байна. | |
| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 8. Хүн амыг амьдралын хэв маягаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл таатай орчинд ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг хангах | | | | | | | |
| 8.1 | Хүн амыг амьдралын хэв маягаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл таатай орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг хангах Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.1 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024, 2024-2027 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.6 дахь заалтын хэрэгжилтийг хангах | - | Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо | 3 | 6 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт дэмжих төв нь тасгийн эрхлэгч, их эмч 4, сувилагч 3 хүний нөөцтэйгээр ЭХО, рентген, ходоодны уян дуран, дотрын кабинет, нүдний кабинет, лорын кабинет, эмэгтэйчүүдийн кабинеттэй, тоног төхөөрөмжийн хангалт 90 хувьтай бүтэц зохион байгуулалттайгаар ажиллаж байна. Эрт илрүүлэг үзлэгт ehealth.mn, hiep.mn, health.gov.mn программуудыг ашиглаж, нэгдсэн сан үүсгэн ажиллаж байна. Эрт илрүүлэгт орсон иргэд emongolia платформоос үзлэгийн дүгнэлтээ авах боломжтой болсон. | 100% |
| | | - | Төлөвлөгөө-ний хэрэгжилтийн дундаж хувь | 90%-иас доошгүй | 90%-иас доошгүй | | |
| 8.2 | “Эрүүл чийрэг эр хүн”, “Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ | - | Төлөвлөгөө-ний хэрэгжилтийн хувь | 90%-иас доошгүй | 90%-иас доошгүй | 12 байгууллагад эрт илрүүлэг, халдварт, халдварт бус өвчнөөс сэргийлэх, стресс менежмент, эрүүл зөв хооллолт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, ЖСА, цус багадалтын шалтгаан, Уур амьсгалын өөрчлөлт- Эрүүл мэнд, Хүнсний бүтээгдэхүүний шошго таньж мэдэх чиглэлээр сургалт явуулж, 771 албан | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагчийг хамруулсан.<br>Ерөнхий боловсролын сургуулийн 2-12 дугаар ангийн сурагчид МБС-ын оюутануудад эрүүл зөв хооллолт, эрүүл мэнд өглөөний цайнаас эхэлдэг, өсвөр насны онцлог, эрт илрүүлэгийн ач холбогдол, хүний папилома вирусийн эсрэг вакцин сэдэвт сургалтууд зохион байгуулж, 2698 хүүхдийг хамруулсан. “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил 2024” нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 20 гаруй эрүүл мэндийн байгууллагуудыг хамруулж, тус тусдаа сэдвээр сургалт сурталчилгаа хийж ажилласан. сурталчилгаа явуулж, гарын авлага тараасан.<br>ХСҮТ-ийн ерөнхий захирал, доктор, дэд профессор Н.Эрдэнэхүү төрийн байгууллагуудын албан хаагчид, сургууль, цэцэрлэгийн эмч нар нийт 60-аад хүнд “МЭДЬЕ, СОНГОЁ, ХИЙЕ” сэдэвт сургалт зохион байгуулсан.<br>Архины нийгэм дэх хор нөлөө, Архи гэр бүлд нөлөөлөх нь сэдвүүдээр зорилтот бүлгийн 56 хүнд харьяа эрүүл мэндийн байгууллагуудын нийгмийн ажилтануудтай хамтран 5 дугаар ЕБСургуулийн болон Толбо сумын ЕБСургуулийн 10 дугаар ангийн 110 хүүхдэд архи согтууруулах ундааны хор уршиг сэдвээр сургалт явуулсан.<br>Дэлхийн тамхигүй өдрийг тохиолдуулан "Тамхи үйлдвэрлэлийн хөндлөнгийн оролцооноос хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалцгаая" уриатайгаар харьяа эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилтнууд 100 гаруй төрийн албан хаагчид болон 450 гаруй сурагчдад сургалтад явуулсан. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар 6 удаа, салхинцэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талаар 12 удаа, вируст гепатитээс сэргийлэх талаар 2 удаа, гэдэсний халдвараас сэргийлэх талаар 3 удаа, халдварт бус өвчний чиглэлээр 15 удаа тус тус мэдээлэл хүргүүлсэн. | |
| 8.3 | “Хавдрын эсрэг” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллана | - | Төлөвлөгө ө-ний хэрэгжилт ийн хувь | 90%-иас доошгүй | 90%-иас доошгүй | “ХАВДРЫН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ АЯН” манай аймагт 4 дэх удаагаа хэрэгжиж, Хавдар судлалын үндэсний төв /ХСҮТ/, ХААН банк, Монголын үндэсний олон нийтийн радио телевизтэй хамтран 14 дахь жилдээ хэрэгжүүлж буй "Хавдрын эсрэг үндэсний аян" 09-р сарын 2-6-нд зохион байгуулагдаж уг аяны хүрээнд давхардсан тоогоор нийт 1660 хүнд үзлэг хийн, хортой хавдар-11, хортой гэж сэжиглэгдсэн-33, хоргүй хавдар -96 тохиолдлыг илрүүлсэн байна. Үзлэгийн явцад 73 эс, 49 эдийн шинжилгээ хийж, хоргүй хавдар авах мэс ажилбар-7, бамбайн хавдрын мэс засал-3 хийгдсэн. 2023 оны 12 дугаар сард 16 ортой хавдрын тасаг шинээр нээгдэж, хавдартай өвчтнүүдэд тусламж үйлчилгээг үзүүлж байна.<br>Эрт илрүүлэг үзлэгт 2022 оны 05 дугаар сарын 01-ээс 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 18-аас дээш насны 64612 иргэнээс 12512 хүн хамрагдаж 19.4 хувьтай байна. Эрт илрүүлэг үзлэг оношлогоонд хамрагдсан нийт 12512 үйлчлүүлэгчдээс ходоодны хавдар 19, элэгний хавдар 7, давсагны хавдар 2, бөөрний хавдар 1, улаан хоолойн хавдар 3, нойр булчирхайн хавдар 1, умайн хүзүүний хавдар 2, умайн хүзүүний хавдарын урьдал 43 тус тус оношлогдсон. Нийт эрт илрүүлгийн 25.4%-д нь хоол боловсруулах замын, 25.2%-нь дотоод шүүрлийн, 16.8%-д нь зүрх судасны, 15%-д бөөр шээсний замын эмгэг, бамбайн зангилаа нь нийт өвчлөлийн 22.6% тус тус эзлэж байна. Хөхний нэг болон олон зангилаа, шохойжилт, элэгний гемангиом, уйланхай, артерийн даралт ихсэлт зэрэг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмгэгүүд шинээр ихээр оношлогдож байгаа. Шинээр оношлогдсон өвчлөл, хавдарын урьдал, хавдарын сэжигтэй тохиолдолыг шаардлагатай онош тодруулах шинжилгээнд хамруулах, эмчлэх эрүүлжүүлэх, хяналтанд авах арга хэмжээг авч ажилласан.<br>0-17 насны хамрагдвал зохих 45072 хүүхдээс 28792 хүүхэд эрт илрүүлэгт хамрагдсанаас 1295 хүүхэд амны хөндийн эмгэгтэй, нүдэнд ил харагдах хөгжлийн эмгэг 13, сонсгол хэвийн бус 11, чих, хамар, хоолойн эмгэгтэй 260, хялар 26, харааны бэрхшээл 19, урвасан зовхи 11, харц эгцэлж харахгүй эмгэгтэй 13, макроцефали 7, микроцефали 2, гидроцефали 1, толгой даахгүй эмгэгтэй 2 хүүхэд байна. Эрүүл мэндийн сайдын “Нүүдлийн эмнэлгийг орон нутагт ажиллуулан эрт илрүүлэх, үзлэг оношилгоо шинжилгээг эрчимжүүлэх тухай” А/150 дугаар тушаалын дагуу Улсын хэмжээнд гуравдугаар шатлалын эмнэлгүүд 21 аймгийн алслагдсан багийн иргэдийг үзлэгт хамруулах ажилаар аймгуудад хуваарилагдан ажилласан юм. Тус үйл ажиллагааны хүрээнд Улсын гуравдугаар төв эмнэлгийн эмч нарын баг манай аймгийн Толбо сум болон Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх эрүүл мэндийн дэмжих төвийг түшиглэн эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, үзлэг оношилгоог 2024 оны 04 дүгээр сарын 08-15-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 800 гаруй хүнийг үзлэгт хамрууллаа. Тухайн үзлэгийн үеэр бамбайн зангилаа 65, хөхний голомтот өөрчлөлт 46, хэвлийн цуллаг эрхтэний эмгэг өөрчлөлт 31, хавдрын сэжигтэй тохиолдол 14 тус тус оношлогдож, тухайн иргэдэд эмийн эмчилгээ зөвлөх, ажиглах, цаашид 2, 3 дугаар шатлалд давтан үзүүлэх, шаардлагатай шинжилгээ оношлогоонд орж, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчид хандах, үзүүлэх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талаар зөвлөгөө өгч ажилласан. | |
| 8.4 | “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллана | - | Төлөвлөгө ө-ний хэрэгжилт ийн хувь | 90%-иас доошгүй | 90%-иас доошгүй | Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан үйл ажиллагандаа хэрэгжүүлэн ажиллаж байгаа. Хэрэгжилт 95%. | 100% |
| 8.5 | “Харшлаас сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллана | - | Төлөвлөгө өний хэрэгжилт ийн хувь | 90%-иас доошгүй | 90%-иас доошгүй | Харшлаас сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна. Өрх болон сумдын ЭМТ-ийн нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн багш, сурагч нарт харшлын өвчнөөс сэргийлэх, эрсдэлийг бууруулах сэдвээр сургалт тогтмол зохион байгуулж байна. Уг сургалтад 30 эрүүл мэндийн багш, 360 сурагч хамрагдсан. 2024 оны эхний 10 сарын байдлаар амбулаториор үйлчлүүлж байгаа ард иргэдэд “Харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр амбулаториор харшлын шалтгаантай хандсан 2500 хүнд харшлаас сэргийлэх зөвлөгөө өгч, 8 төрлийн 470 ширхэг санамж хуудас тараасан. Харшлаас сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор аймгийн төвийн 4 өрхийн ЭМТ, 12 сум, 1 тосгоны ЭМТ-үүд сургууль цэцэрлэг, ард иргэд, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулан ажиллаж байна. Сургууль, цэцэрлэгт 20, ард иргэдэд 17, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 6 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулан ажиллаж байна. Сургууль цэцэрлэгийн хүүхэд 360, 700 ард иргэд, 80 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд танхимын сургалтад хамруулж, иргэдэд 8 төрлийн 680 ширхэг гарын авлага тарааж, харшлын эрсдэлт хүчин зүйлийн талаар сурталчилгаа явуулсан. Мөн Эрүүл мэндийн газрын пэйж хуудас болон өрх, сумдын ЭМТ-үүдийн пэйж хуудсанд ЭМЯ, НЭМҮТ, АӨСҮТ-ээс гаргасан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлэл, инфографикуудыг тогтмол байршуулж ард иргэдэд түгээн ажиллаж байна. | |
| СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 9. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоо шинжилгээнд жил бүр хамруулна. | | | | | | | |
| 9.1 | Халдварт болон халдварт бус өвчлөлийг эрт илрүүлж, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх “Алсын хараа-2050” МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.2.1, 2.2.2,2.2.5, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.2, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагаа хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.1 дэх заалтын хэрэгжилтийг хангах | - | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалт ын дундаж хувь | 39.8 | 44 | Манай аймгийн хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын байдлаар А гепатит 2, С гепатит 1, В гепатит 7, улаанбурхан 9, улаанэсэргэнэ 6, гахай хавдар 2, салхинцэцэг 399, трихмониоз 3, заг хүйтэн 43, тэмбүү 17, нярайн үжил 2, гар хөл, амны өвчин 17, хачиг рекиттиоз 1, ёлом 7, хүүхдийн 6 дахь өвчин 6, цусан суулга 13, бэтэг 2 тохиолдол нийтдээ 558 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, голомтын хариу арга хэмжээ зохион байгуулж, харьяа эрүүл мэндийн төвүүдийг мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Тус халдварт өвчин нь 10000 хүн амд 50.9 промилл ба өмнөх онтой харьцуулахад 17.1 промилээр нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа нь 2024 онд салхинцэцэг өвчний дэгдэлт гарсантай холбоотой юм. Олон хүнийг хамарсан хоолны хордлогот дэгдэлт гараагүй. Харьяа эрүүл мэндийн 4 өрхийн эрүүл мэндийн төвд дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, халдварт өвчний хариу арга хэмжээ, тандалт судалгааг эрчимжүүлэх талаар зөвлөмж хүргүүлсэн. Манай аймагт улаанбурхан өвчний 9 тохиолдол бүртгэгдэж, голомтын тандалт судалгаа болон лабораторийн шинжилгээ хийж, 232 хүний ойрын хавьталыг тогтоож, голомтын дархлаажуулатад 136 хүнийг хамруулан, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, голомтыг таслан зогсоож ажилласан. Эрт илрүүлэг үзлэгт 2022 оны 05 дугаар сарын 01-ээс 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 18-аас дээш насны 64612 иргэнээс 12512 хүн хамрагдаж 19.4 хувьтай байна. Эрт илрүүлэг үзлэг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оношлогоонд хамрагдсан нийт 12512 үйлчлүүлэгчдээс ходоодны хавдар 19, элэгний хавдар 7, давсагны хавдар 2, бөөрний хавдар 1, улаан хоолойн хавдар 3, нойр булчирхайн хавдар 1, умайн хүзүүний хавдар 2, умайн хүзүүний хавдарын урьдал 43 тус тус оношлогдсон. Нийт эрт илрүүлгийн 25.4%-д нь хоол боловсруулах замын, 25.2%-нь дотоод шүүрлийн, 16.8%-д нь зүрх судасны, 15%-д бөөр шээсний замын эмгэг, бамбайн зангилаа нь нийт өвчлөлийн 22.6% тус тус эзлэж байна. Хөхний нэг болон олон зангилаа, шохойжилт, элэгний гемангиом, уйланхай, артерийн даралт ихсэлт зэрэг эмгэгүүд шинээр ихээр оношлогдож байгаа. Шинээр оношлогдсон өвчлөл, хавдарын урьдал, хавдарын сэжигтэй тохиолдолыг шаардлагатай онош тодруулах шинжилгээнд хамруулах, эмчлэх эрүүлжүүлэх, хяналтанд авах арга хэмжээг авч ажилласан. 0-17 насны хамрагдвал зохих 45072 хүүхдээс 28792 хүүхэд эрт илрүүлэгт хамрагдсанаас 1295 хүүхэд амны хөндийн эмгэгтэй, нүдэнд ил харагдах хөгжлийн эмгэг 13, сонсгол хэвийн бус 11, чих, хамар, хоолойн эмгэгтэй 260, хялар 26, хэрааны бэрхшээл 19, урвасан зовхи 11, харц эгцэлж харахгүй эмгэгтэй 13, макроцефали 7, микроцефали 2, гидроцефали 1, толгой даахгүй эмгэгтэй 2 хүүхэд байна. Эрүүл мэндийн сайдын “Нүүдлийн эмнэлгийг орон нутагт ажиллуулан эрт илрүүлэх, үзлэг оношилгоо шинжилгээг эрчимжүүлэх тухай” А/150 дугаар тушаалын дагуу Улсын хэмжээнд гуравдугаар шатлалын эмнэлгүүд 21 аймгийн алслагдсан багийн иргэдийг үзлэгт хамруулах ажилаар аймгуудад хуваарилагдан ажилласан юм. Тус үйл ажиллагааны хүрээнд Улсын гуравдугаар төв эмнэлгийн эмч нарын баг манай аймгийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Толбо сум болон Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх эрүүл мэндийн дэмжих төвийг түшиглэн эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, үзлэг оношилгоог 2024 оны 04 дүгээр сарын 08-15-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 800 гаруй хүнийг үзлэгт хамрууллаа. Тухайн үзлэгийн үеэр бамбайн зангилаа 65, хөхний голомтот өөрчлөлт 46, хэвлийн цуллаг эрхтэний эмгэг өөрчлөлт 31, хавдрын сэжигтэй тохиолдол 14 тус тус оношлогдож, тухайн иргэдэд эмийн эмчилгээ зөвлөх, ажиглах, цаашид 2,3 дугаар шатлалд давтан үзүүлэх, шаардлагатай шинжилгээ оношлогоонд орж, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчид хандах, үзүүлэх талаар зөвлөгөө өгч ажилласан | |
| | | - | Эрт илрүүлэг, багцын болон урьдчилан сэргийлэх үзлэгээр илрүүлсэн өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлсэн хувь | 35.7 | 40%-иас доошгүй | Эрт илрүүлэгт хамрагдаж, өөрчлөлттэй гарсан 5403 хүн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. | 100% |
| | | - | Хорт хавдрын үе шатанд тохирсон эмчилгээ хийлгэсэн хүний хувь | 70-ээс доошгүй | 90-ээс доошгүй | 90% | 100% |
| | | - | Товлолт дархлаажу | 95 | 96%-иас доошгүй | 2024 оны 10 сарын байдлаар товлолын дархлаажуулалтын хамралтын хувь 94%. Вакцин тус бүрээр нь авч үзвэл БЦЖ 99.3%, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | улалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь | | | В гепатит 99.3%, Халдварт саа 94.2%, Тавт 92.3%, Халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцин 92.3%, УГУ 86.7%, А гепатит 94.1%, ПЕВ 92.2%-ийн хамралттай байна. | 100% |
| 9.2 | Хүн амын нас, хүйс, эрсдэлт хүчин зүйлд тулгуурласан багцын эрт илрүүлэг, хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй, тасралтгүй зохион байгуулна | - | Эрт илрүүлгийн хамрагдал-тын дундаж хувь | 35,7 | 40%-иас доошгүй | Эрт илрүүлэг үзлэгт 2022 оны 05 дугаар сарын 01-ээс 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 18-аас дээш насны 64612 иргэнээс 12512 хүн хамрагдаж 19.4 хувьтай байна. Эрт илрүүлэг үзлэг оношлогоонд хамрагдсан нийт 12512 үйлчлүүлэгчдээс ходоодны хавдар 19, элэгний хавдар 7, давсагны хавдар 2, бөөрний хавдар 1, улаан хоолойн хавдар 3, нойр булчирхайн хавдар 1, умайн хүзүүний хавдар 2, умайн хүзүүний хавдарын урьдал 43 тус тус оношлогдсон. Нийт эрт илрүүлгийн 25.4%-д нь хоол боловсруулах замын, 25.2%-нь дотоод шүүрлийн, 16.8%-д нь зүрх судасны, 15%-д бөөр шээсний замын эмгэг, бамбайн зангилаа нь нийт өвчлөлийн 22.6% тус тус эзлэж байна. Хөхний нэг болон олон зангилаа, шохойжилт, элэгний гемангиом, уйланхай, артерийн даралт ихсэлт зэрэг эмгэгүүд шинээр ихээр оношлогдож байгаа. Шинээр оношлогдсон өвчлөл, хавдарын урьдал, хавдарын сэжигтэй тохиолдолыг шаардлагатай онош тодруулах шинжилгээнд хамруулах, эмчлэх эрүүлжүүлэх, хяналтанд авах арга хэмжээг авч ажилласан. 0-17 насны хамрагдвал зохих 45072 хүүхдээс 28792 хүүхэд эрт илрүүлэгт хамрагдсанаас 1295 хүүхэд амны хөндийн эмгэгтэй, нүдэнд ил харагдах хөгжлийн эмгэг 13, сонсгол хэвийн бус 11, чих, хамар, хоолойн эмгэгтэй 260, хялар 26, харааны бэрхшээл 19, урвасан зовхи 11, харц эгцэлж харахгүй эмгэгтэй 13, макроцефали 7, микроцефали 2, гидроцефали 1, толгой даахгүй эмгэгтэй 2 хүүхэд байна. Эрүүл мэндийн сайдын “Нүүдлийн эмнэлгийг орон нутагт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллуулан эрт илрүүлэх, үзлэг оношилгоо шинжилгээг эрчимжүүлэх тухай” А/150 дугаар тушаалын дагуу Улсын хэмжээнд гуравдугаар шатлалын эмнэлгүүд 21 аймгийн алслагдсан багийн иргэдийг үзлэгт хамруулах ажилаар аймгуудад хуваарилагдан ажилласан юм. Тус үйл ажиллагааны хүрээнд Улсын гуравдугаар төв эмнэлгийн эмч нарын баг манай аймгийн Толбо сум болон Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх эрүүл мэндийн дэмжих төвийг түшиглэн эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, үзлэг оношилгоог 2024 оны 04 дүгээр сарын 08-15-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 800 гаруй хүнийг үзлэгт хамрууллаа. Тухайн үзлэгийн үеэр бамбайн зангилаа 65, хөхний голомтот өөрчлөлт 46, хэвлийн цуллаг эрхтэний эмгэг өөрчлөлт 31, хавдрын сэжигтэй тохиолдол 14 тус тус оношлогдож, тухайн иргэдэд эмийн эмчилгээ зөвлөх, ажиглах, цаашид 2,3 дугаар шатлалд давтан үзүүлэх, шаардлагатай шинжилгээ оношлогоонд орж, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчид хандах, үзүүлэх талаар зөвлөгөө өгч ажилласан | |
| | | - | Багцын үзлэгийн хамрагдалтын хувь | 35.7 | 40%-иас доошгүй | 40,1% | |
| | | - | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын хувь | 39,8 | 44 | Аймгийн хэмжээнд нийт 460038 үзлэг хийгдсэнээс 111207 хүн буюу 24 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан. | |
| | | - | Нийт 3 үзлэгээр илрүүлсэн өвчлөлийг эмчлэн | 100 | 100 | Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгээр илэрсэн өвчлөлийг эмчлэх, зөвлөгөө өгөх арга хэмжээг тухай бүр авч ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | эрүүлжүүл-<br>сэн хувь | | | | |
| 9.3 | 30-аас дээш насны иргэдийг 7 төрлийн хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт хамруулж илэрсэн хавдрын үе шатанд тохирсон эмчилгээ хийнэ. | - | Хавдрын эрт илрүүлэгт хамрагдалт ын хувь | 59,7 | 64 | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг түшиглэн зохион байгуулагдаж байгаа хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэг 27173 хүн эрт илрүүлэг үзлэгт хамрагдах ёстойгоос 20198 буюу 74 хувьтай байна.<br>Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэгт 30-60 насны 6756 эмэгтэй хамрагдах ёстойгоос 2772 хүн хамрагдаж, хамрагдалт 41 хувьтай байна. Үүнээс үрэвсэлтэй 44 эмэгтэй оношлогдож, эмчилгээнд 6 хүн, хавдрын урьдлаар 13 хүн оношлогдож, урьдлын эмчилгээнд орсон ба 3 эмэгтэй LEEP эмчилгээнд хамрагдлаа. 2024 оны 11 сарын байдлаар нийт 180 хүн шинээр оношлогдсон ба үүнээс мэс заслын эмчилгээнд орсон 78, бай эмчилгээнд 7 хүн, хими эмчилгээг 2013 оноос нутагшуулаад тасралтгүй зохион байгуулж 42 хүн хими эмчилгээнд орсон байна. | 100% |
| | | - | Хорт хавдрын үе шатанд тохирсон эмчилгээ хийлгэсэн хүний хувь | 70-ээс доошгүй | 90-ээс доошгүй | | |
| 9.4 | Товлолт дархлаажуулалтын арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж, тарилгат халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ. | - | Тухайн жилийн товлолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь | 95 | 96%-иас доошгүй | 2024 оны 10 сарын байдлаар товлолын дархлаажуулалтын хамралтын хувь 94%. Вакцин тус бүрээр нь авч үзвэл БЦЖ 99.3%, В гепатит 99.3%, Халдварт саа 94.2%, Тавт 92.3%, Халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцин 92.3%, УГУ 86.7%, А гепатит 94.1%, ПЕВ 92.2%-ийн хамралттай байна.<br>Дархлаажуулалтын тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө гаргаж, бэлэн байдал хангаж ажиллаж байгаа. 2024 онд нийт эмч ажилчдаас УУ нэмэлт вакцины хамралт 75%-тай байна, УГУ вакцинаас хоцорсон УГУ 1-р тунд 5349 буюу 92%, УГУ 2-р тунд 5936 буюу 93.1%-тай байна. 2023 онд УУ нэмэлт тунгаас хоцорсон 2216 хүүхдийг нөхөн дархлаажуулсан. Бусад шаардлагатай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тохиолдолд ЭМБ-ын ажилчдын гэрийнхэн болон бусад иргэдийн 1378 хүнийг дархлаажуулалтад хамруулсан. ЭМСайдын 2024 оны 08-р сарын 23-ны өдрийн А/359 дугаар тушаалын дагуу 2024 оны 09-р сарын 13-ны өдөр ЭМГ-ын даргын А/60-р тоот тушаал батлагдаж улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах ажлыг зохион байгуулж байна. Манай аймагт нийт 7610 хүн тун вакцин хуваарилагдан ирсэн ба 2024 оны 11-р сарын 19-ны өдрийн байдлаар 6-р сараас 5 насны хүүхэд 4262, жирэмсэн эх 154, архаг хууч өвчтэй болон 65-аас дээш насны 1595 хүн, эмч эмнэлгийн ажилчдын 534, Бусад 432 хүн тус тус хамрагдаж нийт 6977 хүн хамрагдаж 91,6%-тай байна.<br>ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албаны багтай хамтран хүний папилома вирусийн халдварын эсрэг вакцин товлолын дархлаажуулалтанд нэмэгдсэнтэй холбоотой 3 өдөр дэмжлэгт хяналт хийж ажиллалаа. Энэ ажлын хүрээнд Нэгдсэн эмнэлэг, Алтанцөгц сум, Жансая өрхийн ЭМТ-д ажиллаж, дархлаажуулалтын үйл ажиллагаатай танилцаж, мэргэжил аргазүйн зөвлөгөө өглөө. Товлолт дархлаажуулалтын мэдээлэгдсэн хамралтыг баталгаажуулах болон вакцины хадгалалт тээвэрлэлт, чанар аюулгүй байдлыг хангах чиглэлээр Нэгдсэн эмнэлгийн яаралтай туслажийн тасагт үнэлгээ хяналт үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэн ажилсан. Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу дархлаажуулалтын их эмч, жолооч гэсэн 2 хүний бүрэлдэхүүнтэй баг Дэлүүн, Толбо, Алтай, Буянт, Улаанхус, Цэнгэл, Сагсай, Булган, Ногооннуур, Цагааннуур, Алтанцөгц, Баяннуур сумуудын эрүүл мэндийн төв, Жансая, Шипагер, Раушан, Мейрим өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүний папилома | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | вирусын халдварын эсрэг вакциныг товлолд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах болон дархлаажуулалтын үйл ажиллагаа, вакцины хамралт зарцуулалт, хүйтэн хэлхээ, хадгалалт тээвэрлэлтийн байдалд дэмжлэгт хяналт хийж арга зүйгээр ханган ажиллав. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үед Цэнгэл, Буянт, Ногооннуур, Цагааннуур сумын ЭМТөвүүдэд УГУ вакцины хамралтыг нэмэгдүүлэх ажлаар дэмжлэгт хяналт хийж ажилласан. ЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Толбо, Булган, Дэлүүн сумын ЭМТөвүүдэд дархлаажуулалтын үйл ажиллагаа, хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлаар дэмжлэгт хяналт хийсэн.<br>Хүний папиллома вирусын халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах Эрүүл мэндийн сайдын А/455-р тушаалын дагуу 2024 оны 11-р сарын 28-наас эхлэн 11 настай хүүхдийг 1 тунгаар дархлаажуулах ажлыг эхэлсэн 2024 оны 12-р сарын 7-ны өдрийн байдлаар нийт 654 хүүхдийг хамруулсан ба 26%-тай байна. | |
| Стратегийн зорилт 10. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, байгалийн гамшиг шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандан судлах, хариу арга хэмжээ шуурхай авах чадавхийг бүрдүүлнэ. | | | | | | | |
| 10.1 | Хүн амд эрүүл мэндийн боловсролыг олгох арга хэмжээг зохион байгуулж, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх /Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.2.3, Монгол Улсын Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын 2.4.1.7, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван | - | Төлөвлөгө ө ний хэрэгжилт ийн хувь | 96.6 | 97%-иас доошгүй | 12 байгууллагад эрт илрүүлэг, халдварт, халдварт бус өвчнөөс сэргийлэх, стресс менежмент, эрүүл зөв хооллолт, нөхөн үржихүйн эрүүл мэнд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, ЖСА, цус багадалтын шалтгаан, Уур амьсгалын өөрчлөлт- Эрүүл мэнд" Хүнсний бүтээгдэхүүний шошго таньж мэдэх чиглэлээр сургалт явуулж, 771 албан хаагчийг хамруулсан.<br>Ерөнхий боловсролын сургуулийн 2-12 дугаар ангийн сурагчид МБС-ын оюутануудад эрүүл зөв хооллолт, эрүүл мэнд өглөөний цайнаас эхэлдэг, өсвөр насны онцлог, эрт илрүүлэгийн ач холбогдол, хүний папилома вирусийн эсрэг вакцин сэдэвт сургалтууд зохион байгуулж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүтээгдэхүүнийг дотоод хяналтын журмын дагуу газар дээр нь устгаж, 4 худалдааны газарт 12 заалттай албан шаардлага хүргүүлж, хугацаат үүрэг даалгавар өгч ажиласан. Орон нутгийн радиогоор ард иргэдэд мэдээлэл өгсөн.<br>Шалгалтад хамрагдсан худалдааны газруудад Эрүүл мэндийн сайдын 2021 оны 370 дугаар тушаалаар батлагдсан “Сургуулийн орчинд хүүхдэд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалт”-д орсон бүтээгдэхүүн хүүхдэд худалдаалж буй эсэхэд шалгалт хийж, тушаалын танилцуулан, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэл өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан | |
| 18. 15 | Нялх балчир хүүхдийн хүнсний худалдаанд урьдчилсан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Илрүүлсэн зөрчлийн тоо, арилгуулсан зөрчлийн хувь | - | 90% | Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/32 тоот удирдамжийн дагуу аймгийн төвд нялх балчир хүүхдийн хүнс, хооллох хэрэгсэл худалдаалах үйл ажиллагаа эрхэлж буй 5 хүнсний худалдааны газарт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын явцад 11 зөрчил илрүүлж, газар дээр нь 8 буюу 72,72%-ийг арилгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 1 худалдааны газарт 2 заалттай албан шаардлага хүргүүлж, хугацаат үүрэг даалгавар өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>Хяналт шалгалтад хамрагдсан худалдааны газруудад улсын байцаагчийн зөвлөмж тарааж, “Нялх балчир хүүхдийн хүнсний тухай” хууль болон “Зөрчлийн тухай” хуулийг танилцуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн орон нутгийн радиогоор ард иргэдэд мэдээлэл өгсөн. | 100% |
| 18. 16 | Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд урьдчилсан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Обьектын хамралтын хувь<br>Зөрчил | 100%<br>24,7% | 100%<br>25% | Эрүүл мэндийн газрын 2024 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын ерөнхий байцаагчийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | арилгуулалтын хувь<br>Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 67,5% | 68% | баталсан 10/00/10 тоот удирдамжийн дагуу “Зост-Өлгий” зуслангийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. 10.6.7 кодтой хяналтын хуудас”-ны үнэлгээ 48% буюу “дунд” эрсдэлтэй үнэлэгдсэн, 47 зөрчил илрүүлэн 16 зөрчил буюу 34%-ийг газар дээр нь арилгуулсан ба Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр илэрч буй зөрчлийн гадна орчин, барилга байгууламжтай холбоотой зөрчил 7,1%, усан хангамж ариун цэврийн байгууламжтай холбоотой зөрчил 52,6%, амрах байрны эрүүл ахуй шаардлагтай холбоотой зөрчил 50%, хүүхдийн эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой зөрчил 46,1%, хоол үйлдвэрлэлд тавигдах шаардлагатай холбоотой зөрчил 41.1%, дотоод хяналттай холбоотой зөрчил 66%-ийг эзэлж байна. Зөрчил дутагдал арилгуулах 13 заалт бүхий албан шаардлага хүргүүлж ажиллалаа. Зуслангийн эрхлэгч, багш, тогооч, нярав болон холбогдох хүмүүсийг оролцуулан хяналт шалгалтын дүн, анхаарах асуудал, зуслангийн эрүүл ахуйн нөхцөл, хоол, хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалт зохион байгуулав. | |
| 18.17 | Нялх балчир, бага насны, цэцэрлэгийн хүүхэд, ЕБС-ийн бага ангийн сурагчдад зориулсан хүнсний түүхий эд бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд үйл ажиллагаа явуулахаас өмнө урьдчилсан сэргийлэх шалгалт хийх | Улсын төсөв | Хүсэлт шийдвэрлэлт-ийн хувь | 100% | 100% | Хүсэлт ирээгүй. | - |
| 18.18 | Өдөр өнжүүлэх бүлгийн үйл ажиллагаанд урьдчилсан сэргийлэх шалгалт хийх. | Улсын төсөв | Обьектын хамралтын хувь<br>Зөрчил | 100%<br>28% | 100%<br>35% | Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын 10-00/31 тоот удирдамжийн дагуу “Өлгийн сайхан гэрэл” өдөр өнжүүлэх бүлгийн үйл ажиллагаанд урьдчилан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | арилгуулалтын хувь Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 64,7% | 65% | сэргийлэх хяналт шалгалтын хийсэн. Удирдамжид тусгагдсан 11 асуудлын хүрээнд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Шалгалтын явцад өдөр өнжүүлэг бүлгийн багш нарт болон тогоочид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, унд ахуйн уснаас дээж авч СХХ-ийн нэгдсэн лабораторийн шинжилгээнд хамааруулж, лабораторийн шинжилгээний дүнд үнэлэлт дүгнэлт өгч ажилласан. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар 21 зөрил илэрүүлэн 8 буюу 38%ийг газар дээр арилгуулсан. Хяналт шалгалтаар зөрчил дутагдал арилгуулах улсын байцаагчын 7 заалттай албан шаардлага хүргүүлэн ажилласан. | |
| 18.19 | Ундны усны чанар, аюулгүй байдалд урьдчилсан сэргийлэх шалгалт хийх. | Улсын төсөв | Шинжилсэн дээжийн тоо Шаардлага хангаагүй дээжийн хувь | 128<br><br>27,5% | 140<br><br>20% | Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/20 тоот удирдамжийн хүрээнд төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн 2 гүний худаг, халдваргүйжүүлэх, дамжуулах станцаас 6 сорьц, ус түгээх байрнаас 2 сорьц, төвлөрсөн усан хангамжаас 13 сорьц, Өлгий сумын ЗДТГ-ын харьяа 6,9,10-р багуудын ард иргэдийн унд ахуйд хэрэглэдэг 18 гүний худаг, 5 энгийн худгаас 46 сорьц, шинээр баригдаж ашиглалтад орох барилга байгууламжийн худаг болон шугамын уснаас 6 сорьц, Цэнгэл сумын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн гүний худаг болон усан сангаас 2 сорьц, Цагааннуур тосгоны Тамгын газрын харьяа нийтэд түгээдэг гүний худаг, усны машин, булаг шандын уснаас 9 сорьц, Ховд голоос 2 сорьц, нийт 47 цэгээс 83 сорьц авч, аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын хими болон нян судлалын лабораторид 13 үзүүлэлтээр шинжилгээнд хамруулж, шинжилгээний дүнг Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | стандартын шаардлага хангаж буй эсэхэд үнэлгээ дүгнэлт өгсөн. Шинжилгээний дүнгээр нийт ундны усны 0,6% нь кальци, 0,2% нь магнийн хэмжээ, 0,2% нь нийт нянгийн тоо нь стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр гарч, 0,4% нь гэдэсний савханцар буюу E.Coli илэрч, шинжилгээнд хамрагдсан 47 дээжийн 7 /14,8%/ нь ундны усны холбогдох стандартын шаардлага хангаагүй байна.<br>Суат ХХК-ийн төвлөрсөн ус хангамжийн 2 гүний худаг, тойлгойн барилга, ус түгээх байранд хийсэн хяналт шалгалтаар 22 зөрчил илрүүлж 36,4%-ийг газар дээр нь арилгуулж, улсын байцаагчийн 11 заалттай 1 хугацаат албан шаардлага хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажилласан. Хяналт шалгалтаар улсын байцаагчийн шаардлага хангасан 3, хангаагүй 1 дүгнэлт үйлдэж, 1 гүний худгийн үйл ажиллагааг зогсоох 1 акт, үйлдэж 46 иргэнд ундны усны чанар аюулгүй байдал, ашиглалт, хамгаалалтын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, орон нутгийн радиогоор мэдээлэл хийсэн. Аймаг, сумын хүн амыг эрүүл, аюулгүй усаар тогтвортой, хүртээмжтэй хангах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар бүх сумын Засаг даргад газрын даргын албан тоотоор чиглэл хүргүүлж ажилласан.<br>Хүнсний эрүүл ахуйн хяналтын чиглэлээр: 4 хүнсний үйлдвэр, 4 хоолны газраас нийт 16 усны дээж авч нийт 14 үзүүлэлтээр Стандарт хэмжил зүйн хэлтсийн хими, хор судлал, нян судлалын лабораторид шинжилгээнд хамруулахад "MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал.Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ" стандартын шаардлагыг хангаж байна. | |
| 18. | Ахуйн болон урьдчилан | Улсын | Шинжилсэ | 10 | 8 | Салбарын хяналтын газрын даргын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир ус цэвэрлэгээний түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх. | төсөв | н дээжийн тоо Шаардлага хангаагүй дээжийн хувь | 100% | | баталсан 10-00/28 тоот удирдамжийн дагуу аймгийн НААҮ-ний Суат ХХК-ийн харъяа бохир ус цэвэрлэх байгууламжийн орох, гарах хэсгийн бохир уснаас 7 дээж авч аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторид химийн 9 үзүүлэлтээр шинжилгээнд хамруулан, шинжилгээний дүнг “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943-2015” стандартад заасан үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээнд харьцуулан үнэлгээ дүгнэлт өгсөн Цэвэрлэх байгууламжийн орох хэсгийн бохир усны найралган дахь жинлэгдэх бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1,9 дахин их, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч /БХХ/ зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 6 дахин их, перманганатын исэлдэх чанар /ПИЧ/ зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 2,3 дахин их, цэвэрлэх байгууламжийн гарах хэсгийн жинлэгдэх бодис зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1,05 дахин их, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч нь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 4,3 дахин их, перманганатын исэлдэх чанар /ПИЧ/ зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1,4 дахин их, нийт азотын хэмжээ зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 2,36 дахин их, нийт фосфорын хэмжээ зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1,34 дахин их үзүүлэлттэй буюу цэвэрлэгээний үр дүн 28,8% байна.<br>Хяналт шалгалтаар 20 зөрчил илрүүлж, 35%-ийг шуурхай арилгуулж, улсын байцаагчийн 7 заалт бүхий албан шаардлага хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажилласан.<br>Цэвэрлэх байгууламжид үйл ажиллагаанд холбогдох хууль, дүрэм журам стандартын хэрэгжилтийг хангуулан ажиллах талаар холбогдох 2 инженер, 1 лабораторийн эрхлэгч, 4 техникийн ажилтнууд болон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | туслах ажилчдад мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | |
| 18. 21 | Хот, суурин газрын хөрсний бохирдлын түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Шинжилсэн дээжийн тоо<br>Их, дунд бохирдолтой дээжийн эзлэх хувь | 5<br><br>40% | 10<br><br>38% | Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/26 тоот удирдамжийн дагуу аймгийн төвийн суурьшлын бүсийн хөрсний бохирдлын түвшинг тодорхойлохоор Өлгий сумын 11 дүгээр баг дулааны станцын /Эрчим ХК/ орчим, 4 дүгээр баг НААҮ-ний “Суат” ХХК-ийн харьяа төв цэвэрлэх байгууламжийн лагийн талбайн орчим, 9 дүгээр баг Нэгдсэн хогийн цэг орчим, 13 дугаар баг үйлдвэрийн бүсийн нийтийн гудамж талбай, 4 дүгээр баг ЗӨСТөвийн хашааны гадна нийтийн гудамж талбай зэрэг 5 цэг тогтоож, тогтоосон цэгүүдийн координатыг GPS-ээр тодорхойлж, координатжуулж, газрын хөрснөөс нь 5 дээж авч аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн нян судлалын лабораторид шинжилгээнд хамруулсан. Шинжилгээний дүнг Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл, аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх” MNS 3297-2019 стандартын үзүүлэлттэй харьцуулж дүгнэхэд бохирдолгүй гарсан байна. | 100% |
| 18. 22 | Амралтын газар аялал жуулчлалын бааз, зочид буудлын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Хамруулсан обьектын тоо | - | - | Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/30 тоот удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх обьектын жагсаалтад ороогүй 2 зочид буудал, 2 жуулчны баазын орон байрны эрүүл ахуйн нөхцөл байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.<br>Хяналт шалгалтын явцад хэсгийн ус хангамжтай 4 газрын унд, ахуйн уснаас 8 сорьц авч, аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лабораторид итгэмжлэлийн хүрээний дагуу хими болон нян судлалын шинжилгээнд хамруулан, шинжилгээний дүнг “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. MNS 0900:2018 стандартын 3 дугаар хүснэгтэд заасан үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээнд харьцуулан үнэлгээ, дүгнэлт хийхэд бүгд стандартын шаардлагыг хангасан үзүүлэлттэй гарсан.<br>Зочид буудал, жуулчны баазуудад хийсэн хяналт шалгалтаар нийт 109 зөрчил илрүүлж, 46 буюу 42,2% зөрчлийг газар дээр нь арилгуулан, улсын байцаагчийн 63 заалттай 4 албан шаардлагаар үүрэг даалгавар өгч биелэлтийг хяналт тавьж ажилласан.Хяналт шалгалтад хамрагдсан 4 объектын нийт 11 ажилчдад зочид буудал, жуулчны баазуудын эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмийг баримталж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. | |
| 18. 23 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламж барих газар олголт, зураг төсөл зохиох, ашиглалтад хүлээн авахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийх | Улсын төсөв | Хамруулсан обьектын тоо<br>Шаардлага хангасан хувь | 30 обьект<br><br>86,6% | Хүсэлтийн дагуу | Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/02 тоот “Барилга байгууламж барих, газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, ашиглалтад оруулахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу орчны эрүүл ахуй халдвар хамгааллын чиглэлээр 19 хүсэлтийг хүлээж авч хяналт шалгалт хийсэн.<br>Барилга байгууламжийн зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийлгэж дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн 12 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг зураг төсөл болон холбогдох баримт бичгийн хамт хүлээж авч хяналт хийж, богино хугацаанд засч, залруулах боломжтой дутагдлыг газар дээр нь засвар хийлгэж, шаардлага хангасан 9 дүгнэлт гаргаж, 2 зураг төслийг газрын даргын албан тоотоор, 1 зураг төслийг газар дээр нь буцаасан.<br>Аймгийн Засаг даргын 7 захирамжийн дагуу шинээр барьсан 6, өргөтгөл хийсэн 1 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | барилга байгууламжийг ашиглалтад оруулахад эрүүл ахуйн хяналт хийж, илэрсэн дутагдлыг арилгуулах үүрэг даалгавар өгч, биелэлтийг бүрэн арилгасан 6 барилга байгууламжийг ашиглалтад авсан. 1 барилга байгууламжийн үүрэг даалгаврын хугацаа дуусаагүй биелэлт ирүүлээгүй байна. Хяналт шалгалтын явцад Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын 5.5 дахь хэсэгт заасны дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас өмнө ундны усны 5 дээж авч шинжилгээнд хамруулж, үнэлгээ өгөхөд бүгд шинжлэгдсэн үзүүлэлтээр стандартын шаардлага хангасан үзүүлэлттэй гарсан<br>Урьдчилсан хяналтын явцад барилгын зураг төсөлд эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийлгүүлэхгүйгээр барилгын ажил эхэлсэн 2 зөрчлийг илрүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж иргэнийг 250 нэгж буюу 250,000 буюу 2 иргэнд нийт 500,000 төгрөгний шийтгэл ноогдуулж барагдуулсан.<br>Хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр: Барилга байгууламжийн зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийлгэж дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн 10 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг зураг төсөл болон холбогдох баримт бичгийн хамт хүлээж авч хяналт хийж, шаардлага хангасан 10 газарт улсын байцаагчийн дүгнэлт гаргаж хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын 3 захирамжийн дагуу шинээр барьсан барилга байгууламжийг ашиглалтад оруулахад эрүүл ахуйн хяналт хийж, илэрсэн дутагдлыг арилгуулах үүрэг даалгавар өгч, биелэлтийг бүрэн арилгасан 3 барилга байгууламжийг ашиглалтад авсан.<br>Урьдчилсан хяналтын явцад барилгын зураг төсөлд эрүүл ахуйн урьдчилсан хяналт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийлгүүлэхгүйгээр барилгын ажил эхэлсэн 3 зөрчлийг илрүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 3 иргэнд нийт 750,000 төгрөгний шийтгэл ноогдуулж барагдуулсан.<br>Хүүхдийн эрүүл ахуйн чиглэлээр 9 ААНэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн мөрөөр барилгын зураг төсөлд эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийж,илэрсэн зөрчил дутагдалыг үндэслэн 2 аж ахуйн нэгжид 5000000 сая төгрөгийн торгууль тавьж, зураг төсөлд эрүүл ахуйн дүгнэлт гаргасан, Аймгийн Засаг даргын захирамжаар шинээр баригдсан барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд орж шинээр баригдсан сургалтын байгууллагын 10 барилга, 21 обьектын ариун цэврийн байгууламжид урьдчилсан хяналт хийж хяналт шалгалт хийж нийт 134 зөрчил дутагдлыг арилгуулахаар саналын хуудасд тусгаж үүрэг даалгаврын биелэлтээр 10 барилга ашиглалтад авч 3 барилгын үүрэг даалгаврын биелэлт хангуулаагүй тул байнгын ашиглалтад аваагүй. | |
| 18. 24 | Удирдах дээд байгууллагын шийдвэр болон иргэн, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн өргөдөл гомдол, хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Өргөдөл гомдлын шийдвэрл элт-ийн хувь Зөрчил арилгалты н хувь | 2023 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр 157 албан бичиг, 30 өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэс эн ба 30 өргөдөл гомдлыг хүлээн авч 100% | Иргэдийн гомдлыг хууль журмын дагуу 100% шийдвэрлэж , үүсэж болзош гүй эрсдэл ээс урьдчил ан сэргийл нэ. | Тайлант хугацаанд иргэний өргөдөл гомдол, удирдлагаас өгсөн үүргийн дагуу 5 улсын /ахлах/ байцаагч нар 72 обьектод төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 681 зөрчил илрүүлэн газар дээр нь 327 буюу 48%-ийг арилгуулж, 376 заалттай 30 албан шаардлага, 77 заалттай 5 зөвлөмж үйлдэж, үйл ажиллагааны дүгнэлт-6, орон байрны дүгнэлт-1, 6 хуулийн этгээд, 3 иргэнд 12700,0 мянган төгрөгний торгууль, 2490,0 мянган төгрөгний хууль бус орлогыг хурааж, 363150 төгрөгний 294 ширхэг хүнсний бүтээгдэхүүнийг хурааж, шалгалтаар бэлэн хоолны дээж-4, ундны усны дээж-4, гадаад орчны арчдас-120 ширхэг авч лабораторийн шинжилгээнд хамруулж ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | барагдуулсан. | | ХШХ-ийн улсын /ахлах/ байцаагчид тайлант хугацаанд 38 өргөдөл гомдол, 245 албан бичгийг хүлээн авч холбогдох хуулийн дагуу шийдвэрлэж ажилласан. 38 өргөдөл гомдлын мөрөөр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн 7 зөвлөмж, улсын байцаагчийн 13 дүгнэлт, 4 албан шаардлагаар зөрчил арилгуулах үүрэг даалгавар, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн-5, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан-4, албан бичгээр хариу өгсөн-4 байна.<br>2024 онд 245 албан бичиг хүлээн авсан ба СХГ-аас удирдамж-22, аймгийн ЗД-ын захирамж-24, үүнээс хугацаагүй албан бичиг-11, хариутай албан бичиг-188 байна.<br>Албан бичгийн мөрөөр улсын байцаагчийн дүгнэлт-94, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн-40, харьяаллын дагуу шилжүүлсэн-4, илтгэх хуудас, танилцуулга бичсэн-25, албан бичгээр хариу өгсөн-16 байна.<br>Газрын даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу 10-15/05 тоот удирдамж батлуулан Өлгий сумын төвд үйл ажиллагаа явуулж буй үсчин, гоо сайхны газруудын эрүүл ахуй халдвар хамгааллын нөхцөл байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, холбогдох хяналтын хуудасаар эрсдлийн үнэлгээ хийж ажилласан. Нийт 20 үсчин, гоо сайхны газрыг 10.10.9, 10.10.8 кодтой хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд 17 газар “их”, 3 газар “бага” эрсдэлтэй үнэлэгдсэн. Шалгалтаар нийт 342 зөрчил илрүүлж 26%-ийг газар дээр нь арилгуулж, үлдсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 174 заалттай 20 албан шаардлагаар хугацаат үүрэг даалгавар өгч, орон байр нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй, халдвар хамгааллын дэглэм алдагдсан 2 газар болон цэвэр бохир нь төвлөрсөн болон хэсгийн шугам сүлжээнд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбогдоогүй 3 газрын үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар түр зогсоох арга хэмжээ авсан. Албан шаардлагын биелэлтэд хяналт тавьж биелэлтийг хангуулан ажиллаж байна.<br>Мөн газрын даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу 10-15/11 тоот удирдамжийн хүрээнд Өлгий сумын төвд үйл ажиллагаа явуулж буй 4 нийтийн үйлчилгээний бялдаржуулах, чийрэгжүүлэх төв буюу фитнесийн төвүүдийн орон байрны эрүүл ахуйн нөхцөл шаардлага болон үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 10.10.4 кодтой хяналтын хуудас”-аар эрсдэлийг үнэлэхэд 3 газар “их”, эрсдэлтэй үнэлэгдсэн. 1 газрын фитнесийн үйл ажиллагаа хаагдсан байна. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр 26 заалттай 3 албан шаардлагаар хугацаат үүрэг даалгавар өгч ажилласан. | |
| 18.<br>25 | Гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Албан шаардлагын биелэлт /тоо,хувь/ Зөрчил арилгалт хувь | 2023 онд 60 обьектод гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн ба Албан шаардлагын хэрэгжилт-58-85%-ийн биелэлттэй. | Албан шаардлагаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг дүгнэж тайлагнана. | Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалтаар албан шаардлага өгөгдсөн 85 обьектын 64 буюу 75,2%-ийг гүйцэтгэлийн хяналт шалгалтанд хамруулсан ба 30 объект “их” эрсдэлээс “дунд”, 14 объект “дунд” эрсдэлээс “бага” эрсдэл руу шилжсэн бөгөөд Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар албан шаардлагын хэрэгжилт 70%, хууль тогтоомжийн биелэлт 72%, эрсдэл үүсэх магадлал 47% байна. | 100% |
| 18.26<br>. | Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа цэцэрлэг ерөнхий боловсролын сургуулиудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулах | Улсын төсөв | Хамрах обьект-8 | Хийгдэж байгаагүй | - | Салбарын ерөнхий байцаагч нарын хамтран баталсан 03-00/02 дугаар удирдамжийн дагуу урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Өлгий сумын 10, 11, 23, 24 дүгээр хүүхдийн цэцэрлэг, Өлгий сумын 18, 19, 20 дугаар цэцэрлэгүүдийн салбар бүлэг, Цэнгэл сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийг хамруулсан. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 10.6.1 кодтой “Цэцэрлэгийн эрүүл ахуй, халдвар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамгааллын хяналтын хуудас”, 10.6.2 кодтой “Сургуулийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын хуудас”-аар Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэлээр хяналт шалгалтын явцад 217 зөрчил дутагдал ирүүлэн 34.5%-ийг газар дээр арилгуулан ажилласан. 1 цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоох акт үйлдэн, цэцэрлэгийн үйл ажиллагааг зөрчил арилтал түр зогсоох актын биелүүлээгүй 3 цэцэрлэгийн эрхлэгчид тус бүр 1500000 торгох шийтгэл оногдуулсан. Хяналт шалгалтаар зөрчил арилгуулах 98 заалттай 7 албан шаардлага хүргүүлэн ажилласан. | |
| СТРАТЕГИ ЗОРИЛТ19. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2021 оны А/751 дүгээр захирамжийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 19.1 | Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх аргачлалын дагуу харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тусгайлсан хяналт-шинжилгээ, үнэлгээний хийх ажлыг зохион байгуулах, хяналт тавих | 4.0 сая | Хийгдсэн хяналт үнэлгээний тоо | 27 | 30 | “Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх нийтлэг аргачлал” дагуу Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/10 дугаар тушаалаар Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад хийх хяналт үнэлгээ, шалгалтын төлөвлөгөө, хуваарийг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус тушаалаар өмнө хяналт үнэлгээ, хяналт шалгалт тус тусдаа хийгдэж, давхардал үүсч, харьяа байгууллагуудад хяналт үнэлгээ, шалгалтад жигд бус хамрагдаж байсныг зохицуулсан. Төлөвлөгөөний дагуу тус оны эхний хагас жилийн байдлаар Эрүүл мэндийн газраас харьяа эрүүл мэндийн байгууллагуудад нийт 35 удаагийн хяналт үнэлгээ зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 50 байгууллагыг хамруулсан байна. Үүнд:<br>Өрхийн ЭМТ-ийн үйл ажиллагааны явцын үнэлгээ, эх, хүүхдийн идэвхтэй хяналт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, магадлан итгэмжлэлд орох харьяа байгууллагуудад | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | явцын үнэлгээ, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийн явц, статистик мэдээлэл, шинээр тусгай зөвшөөрөл хүсэгч байгууллагуудын орон байрыг үнэлэх, өргөдлийн мөрөөр болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааг гурвалсан гэрээний дагуу хагас, жилээр дүгнэх хяналт үнэлгээнүүд хийгдэж, мэргэжил арга зүйгээр хангаж, зөвлөмжүүд хүргүүлж ажиллалаа. | |
| 19.2 | Эрүүл мэндийн газрын болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, зөвлөмж хүргүүлж, дүгнэлтийг удирдлагад танилцуулах | 1.0 сая | Хийгдсэн дотоод хяналт, зөвлөмж, дүгнэлтийн тоо | 3 | 6 | Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад дотоод хяналт үнэлгээ хийх төлөвлөгөө гарган хуваарийн дагуу НЭ-т 2 удаа, 4 сум, 4 өрхийн эрүүл мэндийн төвд буюу нийт 10 удаа хяналт үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэн ажилласан. | 100% |
| 19.3 | Шилэн дансны тухайн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 заалтыг хэрэгжүүлэх, харьяа байгууллагуудын шилэн дансны хөтлөлтөнд хяналт тавих | 0.1 сая | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг, хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх гэсэн зарчмуудыг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлэн, цаашид зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган ажиллах талаар зөвлөмж хүргүүлэн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн ил тод байдлыг хангуулах зорилгоор шилэн дансны хөтлөлт болон цаг тухайд нь хууль журмын дагуу байршуулсан эсэхэд байнга хяналт тавьж ажиллаж байна. Харьяа байгууллагуудад шилэн дансны хөтлөлтийг хугацаандаа оруулж хэвших талаар албан бичиг хүргүүлэн арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | 100% |
| 19.4 | Эрүүл мэндийн сайдын 2013 оны 140 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх, мэдээллийн технологийг боловсронгуй | 10.0 сая | Цахим хуудасны хөтлөлт, цахимд шилжсэн | 60% | 70% | ЭМС-ын 2014 оны 140 тоот тушаалын хүрээнд харьяа байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулж интернэт сүлжээг бүрэн шилэн кабелд шилжүүлж,аймгийн Нэгдсэн Эмнэлэг e-health программыг сумын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болгож, цахим эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлэх | | үйл ажиллагаа | | | ЭМТөвүүд health.gov.mn программыг ашиглаж ард иргэдэд үзлэг, шинжилгээний хариуг цахимаар үзүүлэн иргэд E-mongolia ашиглан цаг хугацаа орон зайнаас үл хамааран эрүүл мэндийн бүх төрлийн үйлчилгээг цахимаар авч байна. ЭМГ нь www.health.bo.gov.mn цахим хуудас болон Баян-Өлгий Эрүүл Мэндийн Газар фэйсбуук хуудас ашиглан иргэдийг мэдээ мэдээлэлээр хангаж байна.<br>НЭ, Өрх сумын ЭМТөв Тосгоны ЭМТөв, Өрхийн ЭМТөвүүд 1313.mn сайтаар иргэд цахимаар сэтгэл хэнэмжийн үнэлэгээ өгдөг болсон мөн mail.gov.mn төрийн цахим шууданг эрүүл мэндийн ажилтан албан хаагчид ашиглаж байна. Булган, Ногооннуур сумдууд телемедицин төхөөрөмжөөр хангагдаж цахимаар сургалт, зөвөлгөөн авдаг болсон. Албан бичиг хөдлөлтийн ERP-системийг харьяа эрүүл мэндийн байгууллагуудаддаа нэвтрүүлэв. gov.mn цахим сайтад байгууллагын цахим хуудасыг хөтлөн мэдээлэл оруулж байна. | 100% |
| 19.5 | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх, статистик тоо мэдээллийн үнэн бодит байдлыг хангаж, шийдвэр гаргагчдыг цаг тухайд нь мэдээллээр хангах | 1.0 сая | Мэдээний чанар, боловсруул сан мэдээллийн тоо | 15 | 15 | Тайлант онд нийт 12 удаа сарын мэдээ гаргаж, статистик тоо мэдээллийг анхан шатны маягттай тулгаж, мэдээний үнэн бодит байдлыг хангасан. Нийт 12 удаа 6 хуудас бүхий сарын мэдээг өмнөх онтой харьцуулсан байдлаар гаргаж, аймгийн ЗДТГ-ын НБХ, Статистикийн хэлтэс, эрүүл мэндийн байгууллагуудын, удирдлага, хэлтсийн дарга болон мэргэжилтнүүдэд тухай бүрт шаардлагатай мэдээллээр хангаж ажиллаж байна. Харьяа байгууллагуудын статистик мэдээллийн үнэн бодит байдлыг хангах зорилгоор 4 удаа эргэн мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн. ЭМСайдын 2022 оны 139 дүгээр тушаалын дагуу урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ оношилгооны статистик тоо мэдээнүүдийг аксис программын мэдээний баазыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиглан 7 хоног болгон харьяа эрүүл мэндийн байгууллага, өрх сумаар нь гаргаж, шийдвэр гаргагчдад нийт 46 удаа мэдээ гаргаж өгсөн. 4 өрхийн эрүүл мэндийн төвийн мэдээ тайлан, анхан шатны маягтын үнэн зөв хөтлөлт болон мэдээлж буй тоон мэдээллийг эх материалтай нь тулгаж, дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, тухай бүрт нь алдаа дутагдлуудыг арилгаж, зөвлөгөө өгч ажилласан. | |
| СТРАТЕГИ ЗОРИЛТ 20. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах | | | | | | | |
| 20.1 | Хяналтын чиглэл бүрээр эрүүл мэнд, сургалтын байгууллага, хүнс болон нийтийн үйлчилгээний байгууллагуудад салбарын сургалт зохион байгуулах | Улсын төсөв | Нийтдээ 240 аж ахуйн нэгж байгууллагын 2450 ажилтнуудад зохион байгуулсан. 12 нэр төрлийн гарын авлага зөвлөмжөөр хангаж ажилласан. | 224 байгууллага, аж ахуйн нэгжийн 550 иргэн, албан тушаалтнуудыг хамааруулсан. | Холбогдох мэдээ мэдээллээр хангагдсан байна. | Тайлант хугацаанд эрүүл мэндийн байгууллага, боловсролын салбар, хүнсний чиглэлийн аж ахуйн эрхлэгч 121 байгууллага, аж ахуйн нэгжийн 536 албан тушаалтан, хүнд 10 удаагийн сургалт зохион байгуулсан.<br>Аймгийн Засаг даргын тамгын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас "Барилгын салбарын бүтээн байгуулалт, хариуцлага, хууль эрх зүйн орчин хангуулах" сэдвээр барилгын салбарын удирдах ажилтнууд, инженер техникийн ажилтнуудад зохион байгуулсан "Барилга-2024" зөвлөгөөнд оролцож "Барилгын зураг төсөлд тавих эрүүл ахуйн урьдчилсан хяналт"-ын талаар мэдээлэл хийж, харилцан санал солилцлоо.Нийт 45 хүн оролцсон.<br>ХХААХҮЯ-аас "Хүнсний аюулгүй байдал. Хүнс эрүүл бол хүн эрүүл" сарын аяны нээлтэд оролцож, нээлтийн үйл ажиллагаанд оролцсон хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч ААН, иргэдэд 50 ширхэг хоолны хордлогоос сэргийлэх чиглэлээр зөвлөмж тарааж ажилласан.<br>Өлгий сумын ЗДТГазраас хэлэлцүүлэгт оролцсон. Захиргааны журмаар хураагдсан бараа бүтээгдэхүүний зардал, устгалын талаар гарц шийдлийн талаар саналаа солилцлоо. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ЭМЯ-ны Салбарын хяналтын газрын 9/1238 дугаартай албан бичгийн дагуу Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр Улаанбаатар хотод 2024 оны 05 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд зохион байгуулсан Эрүүл мэндийн салбарын улсын байцаагчдын зөвлөгөөнд 4 улсын /ахлах/ байцаагчид оролцсон.<br>Өлгий сумын ЗДТГ, БОАЖГ, МЭХ-ны салбар хорооноос хамтран зохион байгуулсан "Эх дэлхий ба эмэгтэйчүүд" сургалт, зөвлөгөөнд 3 улсын /ахлах/ байцаагч оролцсон<br>ТАЗ-өөс зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтанд хамрагдсан. Аймгийн Прокурорын газраас зохион байгуулсан " Эрүүл шүүлтээс ангид байх, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт оролцсон.<br>ЭМЯ-ны СХГ-аас зохион байгуулсан 5 удаагийн цахим сургалтанд хамрагдсан. | |
| 20.2 | Хяналт шалгалтын дүнгийн талаар болон хяналтын чиглэл бүрээр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, сэрэмжлүүлэг, зөвлөмж өгөх | Улсын төсөв | Хяналт шалгалтын ажиллагаа ил тод байна. Иргэдийг мэдээ, мэдээллээр хангана. | 2023 онд 5 хяналтын чиглэлээр орон нутгийн радиогоор-9 удаа, телевизээр-6 удаа мэдээлэл, сэрэмжлүүлэг, зөвлөмж хүргүүлсэн. | Иргэд мэдээ, мэдээллээр хангагдана. | Тайлант хугацаанд хяналт шалгалтын дүнгийн талаар телевизээр-4 удаа, радиогоор-2 удаа, хүнсний аюулгүй байдлыг хангуулах, хоолны хордлогот халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр телевизээр-4 удаа, радиогоор-4 удаа, нийтдээ 14 удаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр, байгууллагын фейж хуудас, ФБ хуудсаар 34 удаа ард иргэдэд мэдээ мэдээлэл, сэрэмжлүүлэг хүргэсэн байна. | 100% |

Нийт 20 зорилтын хүрээнд төлөвлөсөн 122 төрлийн арга хэмжээний биелэлт 99,5% байна.
119 арга хэмжээ100%,
2 арга хэмжээний 90%,
1 арга хэмжээний 70% биелэгдсэн.

Төлөвлөгөөг хянасан: Төсвийн Ерөнхийлөн захирагч

ЗАСАГ ДАРГА ......................... Е.ЗАНГАР

(албан тушаал)                    (гарын үсэг)

2024 оны 12 дугаар сарын 12

Тэмдэг

Төлөвлөгөө тайлагнасан:                                Төсвийн Шууд захирагч

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА:    .........................                Н.САКЕН

(албан тушаал)                                (гарын үсэг)

2024 оны 12 дугаар сарын 12

Тэмдэг